



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/24

Мөрөн сум

Газрын талбайн хэмжээнд өөрчлөлт
оруулж, эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 1 иргэн, 2 аж ахуйн нэгжийн гаргасан хүсэлтийн дагуу 0.4532 га (0.4532м²) газрын газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Ганзориг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

ийн Засаг даргын 2022 оны
эр сарын 25-ны өдрийн
ар захирамжийн хавсралт

НЭГЖИЙН ЖАГСААЛТ

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Иргэндийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Өөрчилж, нэмэлт оруулж буй захирамжийн багана	Тайлбар
1	Буузан овгийн Ганбат Ганбаяр /АЗ84051419/	6712008649	7-р баг 31-106 тоот	Аймгийн Засаг даргын 2015.05.07-ны өдрийн А/167 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 5 дахь заалтын 6 дахь баганын "359м ² " гэснийг "435м ² " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /кадастрын хэмжилтээр/
2	"НИК" ХК /РД:2075261/	Шинээр	6-р баг Аюулгүйн тойрог "3 дугаар станц"	Сумын Засаг даргын 2006.03.29-ний өдрийн №43 дугаар захирамжийн хавсралтын холбогдох хэсгийн газрын талбайн хэмжээ "500м ² " гэснийг "1271м ² " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх кадастрын хэмжилтээр /6712011400 идэвхигүй нэгж талбарын дугаарыг өөрчлөлтөд оруулах/
3	"Эрч центр" ХХК /РД:4131185/	Шинээр	8-р баг Даваадорж-1 115 тоот	Аймгийн Засаг даргын 2021.09.08-ны өдрийн А/408 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалтын 7 дахь заалтын "515м ² ", 2 дахь заалтын 7 дахь баганын "2311м ² " нэгж талбаруудыг нэгтгэж "2826 м ² " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /6712016960, 6712014670 нэгж талбаруудыг нэгтгэх/

M. J. H.